



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/59

Мөрөн сум

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/32 дугаар захирамж, хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 03/25 дугаар актыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд “Төгс гранд констракшн” ХХК-н ажлын зураг төсөв боловсруулах 320,000,000 (Гурван зуун хорин сая) төгрөгийн өртөг бүхий сумын төвийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын зураг төсөв /Тариалан сум/-г эзэмших байгууллагыг хавсралтаар баталсугай.

2. Хөрөнгийг эзэмшигч байгууллагад хүлээлгэн өгөх ажлыг шуурхай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Э. Аззаяа)-д хариуцуулсугай.

3. Хуваарилагдсан хөрөнгийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу холбогдох дансанд бүртгэж, ҮХ-1 баримтыг Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг холбогдох байгууллагын нягтлан бодогчид үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Цэнддэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



Ц.БЭХБАЯР

Орон нутгийн өмчийн газрын даргын
2025 оны 08 дугаар сарын 12-ны
өдрийн А/39 дугаар тушаалын хавсралт



ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр төрөл	Марк	Тоо хэм- жээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Эзэмших байгууллага
1	Зөвлөх үйлчилгээ /Зураг төсөв/		1	320,000,000	320,000,000	Тариалан сумын Засаг даргын Тамгын газар
	Дүн				320,000,000	

оОо

